



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/1571

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 157 дугаар  
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,397,600 /дөрвөн сая гурван зуун ерэн долоон мянга зургаан зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 21,600 /хорин нэгэн мянга зургаан зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 8 нэр төрлийн 4,376,000 /дөрвөн сая гурван зуун далан зургаан мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115060001397

Нийслэлийн Өмчийн Ашиглалт, Удирдлагын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 09 өдрийн

1119282495-дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж											
1	Хелдеегч	8	ш	1	350,000.00	350,000.00	350,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
2	Тоос сорогч	7	ш	1	120,000.00	120,000.00	120,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
3	Принтер	6	ш	1	229,000.00	229,000.00	229,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
4	Принтер T50	4	ш	1	589,000.00	589,000.00	589,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
5	Принтер	5	ш	1	189,000.00	189,000.00	189,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн											
					1,477,000.00	1,477,000.00					
Тавилга, эд хогшил											
1	Ханын шкаф	34	ш	1	21,600.00	21,600.00	21,600.00	-	эвдэрсэн	актлах	устгах
Тавилга, эд хогшлын дүн											
					21,600.00	21,600.00					
Бусад үндсэн хөрөнгө											
1	4 сандалтай эргэдэг тоглоом	10	ш	1	977,000.00	977,000.00	977,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
2	1 суудалтай савлуур	10	ш	1	950,000.00	950,000.00	950,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
3	2 суудалтай савлуур	10	ш	1	972,000.00	972,000.00	972,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
Бусад үндсэн хөрөнгийн нийт дүн											
					2,899,000.00	2,899,000.00					
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн											
					4,397,600.00	4,397,600.00					
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө											
					4,376,000.00	4,376,000.00					
					21,600.00	21,600.00					
Актлах хөрөнгө											